

2020 ОНЫ 3 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ


2020 оны 3 дугаар сард эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдлийн мэдээг 6 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ, НЭМГ/ ирүүлсэн. ГССҮТ, УАУТХ, ЭХЭМҮТ эмнэлгүүдээс мэдээ ирээгүй.

Нэг. Амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:

2020 оны 3 дугаар сард 1319 үйлчлүүлэгч үйлчлүүлснээс 801 үйлчлүүлэгч өдөртөө үйлчлүүлсэн байна. 1 ба түүнээс дээш хоногоор хүлээсэн 518 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна. Тухайлбал:

УНТЭ 1, УХТЭ 3, УГТЭ 104, ХСҮТ 410 хүлээгдэл тус тус бүртгэгдсэн байна. Харин СЭМҮТ, НЭМГ амбулаторийн хүлээгдэлгүй ажилласан байна. Үүнийг өмнөх хоёр сарын хүлээгдэлтэй харьцуулан авч үзвэл УНТЭ, УХТЭ, УГТЭ-ийн хүлээгдэл буурсан байгаа бол ХСҮТ-ийн хүлээгдлийн тоо өссөн үзүүлэлттэй гарсан байна.

УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн 2020 оны 3 дугаар сарын амбулаторийн хүлээгдлийг харьцуулсан нь:



Амбулаторийн хүлээгдлийг ЭМБ-аар авч үзэхэд:

УНТЭ-ийн амбулаторийн булчирхай судлалын кабинетад нэг хоногийн хүлээгдэлтэй үйлчлүүлсэн 1 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх сарын амбулаторийн хүлээгдлээс 93 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр буурсан байна.

УХТЭ-т нийт 2 кабинетад 3 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын амбулаторийн хүлээгдлээс 82 хүлээгдлээр буурсан байна. Үүнд:

Бөөр судлалын кабинетад 2, хоол боловсруулах эрхтэн судлалын кабинетад 1 үйлчлүүлэгч тус бүр 1 хоногийн хүлээгдэлтэй үйлчлүүлсэн байна. Өдөртөө 212 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн байна.


УГТЭ-ийн 3 кабинетад нийт 104 хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 10 хүлээгдлээр буурсан байна. Үүнд:

Зүрх судасны кабинетад 54, уушигны кабинетад 18, мэдрэл судлалын кабинетад 32 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 460 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

ХСҮТ-ийн 12 кабинетад нийт 410 хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд:

Мэс заслын кабинетад 8, зүрх судасны кабинетад 50, толгой хүзүүний мэс заслын кабинетад 38, туяа эмчилгээний кабинетад 16, химийн кабинетад 65, хөнгөвчлөх тусламж үйлчилгээний кабинетад 10, цээжний хөндийн мэс заслын кабинетад 45, элэг цөс, нойр булчирхайн кабинетад 56, Гепатологийн кабинетад 26, ангиографын кабинетад 29, эмэгтэйчүүдийн мэс заслын кабинетад 67 хүлээгдэл нь 1 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Өдөртөө үйлчлүүлсэн 150 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.


УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн 2020 оны 3 дугаар сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



Хоёр. Оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2020 оны 3 дугаар сард 784 үйлчлүүлэгч үйлчлүүлснээс 462 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн байна. Оношлогооны кабинетуудад 322 хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 99 хүлээгдлээр буурсан үзүүлэлт харагдаж байна.

Үүнд: УНТЭ 6, УХТЭ 4, УГТЭ 98, СЭМҮТ 80, ХСҮТ-д 134 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна.



Оношлогооны хүлээгдлийг ЭМБ-аар авч үзэхэд:

УНТЭ-ийн ходоодны дурангийн оношлогооны кабинетад 6 үйлчлүүлэгч 2 хоногийн хүлээгдэлтэй үйлчлүүлсэн байна. Энэ нь өмнөх сарын хүлээгдлээс 25 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр буурсан байна.

УХТЭ-т нийт оношлогооны 2 кабинетад 4 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 121 хүлээгдлээр буурсан байна. Үүнд:


Хэвлийн ЭХО 1, тархины цахилгаан бичлэг 3 тус бүр 1-3 хоногийн хугацаатай хүлээгдэл байна. Өмнөх сарын оношлогооны кабинетын хамгийн их хүлээгдлээр тус эмнэлгийн хэвлийн ЭХО-ны кабинетад 76 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байсан бол энэ сард 1 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэнээр хүлээгдэл буурсан таатай үзүүлэлт харагдаж байна.

УГТЭ-ийн 3 кабинетад нийт 98 хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 1 хүлээгдлээр буурсан байна. Үүнд: Рентген зураг 12, зүрхний цахилгаан бичлэг 61, хэвлийн ЭХО 25 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өмнөх сар тус тасгуудад хүлээгдэл бүртгэгдсэн байсан ч хүлээгдлийн тоогоор зүрхний цахилгаан бичлэгийн кабинетын хүлээгдэл өссөн, рентген зураг, хэвлийн ЭХО-ны кабинетын хүлээгдэл буурсан үзүүлэлттэй байна.

СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын оношлогооны кабинетад 80 үйлчлүүлэгч 2 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй бүртгэгдсэн байна.

ХСҮТ-ийн 5 кабинетад нийт 134 хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд: Рентген зураг 28, КТГ 1, зүрхний цахилгаан бичлэг 44, хэвлийн эхо 28, ходоодны дуран 33 үйлчлүүлэгч тус бүр 2 ба түүнээс дээш хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Тус кабинетууд сүүлийн хоёр сар тогтмол хүлээгдэлтэй ажиллаж байгаа ч рентген зураг, хэвлийн эхоны кабинетын хүлээгдэл буурсан, зүрхний цахилгаан бичлэг, ходоодны дурангийн кабинетын хүлээгдэл нэмэгдсэн байна.

Оношлогооны кабинетын хүлээгдэл



УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн оношлогооны кабинетийн 2020 оны 2, 3 дугаар сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:

№	Үзлэгийн кабинетын нэр	УНТЭ		УХТЭ		УГТЭ		ХСҮТ		СЭМҮТ		Нийт	
		2 сар	3 сар	2 сар	3 сар	2 сар	3 сар	2 сар	3 сар	2 сар	3 сар	2 сар	3 сар
1	Рентген зураг	15	-	3	-	24	12	59	28	-	-	101	40
2	Зүрхний цахилгаан бичлэг	-	-	38	-	45	61	32	44	-	-	115	105
3	Эхо /хэвлий/	-	-	76	1	30	25	71	28	-	-	177	54
4	Бамбайн ЭХО	-	-	-	-	-	-	2	-	-	-	2	-
5	Ходоодны дуран	-	6	-	-	-	-	16	33	-	-	16	39
6	Холтер	-	-	1	-	-	-	-	-	-	-	1	-
7	Тархины цахилгаан бичлэг	2	-	2	3	-	-	-	-	-	-	4	3
8	Допплеро-графи	3	-	-	-	-	-	-	-	-	-	3	-
9	Нүдний уг харах	-	-	2	-	-	-	-	-	-	-	2	-
10	MRI	-	-	3	-	-	-	-	-	-	-	4	-
11	Бүдүүн гэдэсний дуран	6	-	-	-	-	-	-	-	-	-	6	-
12	Зүрхний эхо	3	-	-	-	-	-	-	-	-	-	3	-
13	КТГ	1	-	-	-	-	-	1	1	-	-	2	1
14	Урологийн оношлогооны дуран	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
15	Эмгэг сэтгэл судлал	-	-	-	-	-	-	-	-	-	80	-	80
Нийт		31	6	125	4	99	98	181	134	-	80	124	421

Дүгнэлт: 2020 оны 3 дугаар сард 784 үйлчлүүлэгч үйлчлүүлснээс 462 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн ба УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн оношлогооны кабинетуудад 322 хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 99 хүлээгдлээр буурсан үзүүлэлт харагдаж байна. Сүүлийн хоёр сар тогтмол хүлээгдэлтэй байгаа кабинетуудаар рентген зургийн кабинет, зүрхний цахилгаан бичлэгийн кабинет, хэвлийн эхоны кабинет, ходоодны дурангийн кабинетүүд байна.

Гурав. Лабораторийн шинжилгээний хүлээгдэл:

2020 оны 3 дугаар сард УНТЭ, СЭМҮТ, ХСҮТ эмнэлгүүд лабораторийн шинжилгээний хүлээгдэлгүй ажилласан байна.

Лабораторийн шинжилгээний хүлээгдэл ЭМБ-аар:

УХТЭ-т лабораторийн шинжилгээний хүлээгдэл бүртгэгдсэнийг дүгнэхэд: Нийт 917 үйлчлүүлэгч үйлчлүүлснээс 828 үйлчлүүлэгч өдөртөө үйлчлүүлсэн бол лабораторид шинжилгээ өгөхөөр 89 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн байна. Өмнөх сарын хүлээгдлээс 60 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн байна. Үүнд:

Цусны ерөнхий шинжилгээ 6, шээсний ерөнхий шинжилгээ 4, биохимийн шинжилгээ 71, бактериологийн шинжилгээ 1, иммунологийн шинжилгээ 5, серологийн шинжилгээ 2 үйлчлүүлэгч тус бүр хүлээж үйлчлүүлсэн байна.

УГТЭ-т нийт 449 үйлчлүүлэгч үйлчлүүлснээс 352 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн бол лабораторид шинжилгээ өгөхөөр 97 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн байна. Өмнөх сарын хүлээгдлээс 20 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн байна. Үүнд: Цусны ерөнхий шинжилгээ 49, биохимийн шинжилгээ 48 үйлчлүүлэгч тус бүр хүлээж үйлчлүүлсэн байна.

УХТЭ, УГТЭ оношлогооны кабинетийн 2020 оны 3 дугаар сарын хүлээгдлийг кабинетээр харьцуулсан нь:



**УХТЭ, УГТЭ-үүдийн 2020 оны 2,3 дугаар сарын лабораторын шинжилгээний
хүлээгдлийн мэдээ**

№	Үзлэгийн кабинетын нэр	УХТЭ		УГТЭ		Нийт	
		2 сар	3 сар	2 сар	3 сар	2 сар	3 сар
1	Цусны шинжилгээ	2	6	39	49	41	55
2	Шээсний шинжилгээ	2	4	0	-	2	4
3	Биохими	21	71	38	48	59	119
4	Бактериологи	1	1	0	-	1	1
5	Иммунологи	2	5	0	-	2	5
6	Серологи	0	2	0	-	0	2
7	Цитологи	0	-	0	-	0	-
8	Коагулограмм	1	-	0	-	1	-
Нийт		29	89	77	97	106	186

Дүгнэлт: 2020 оны 3 дугаар сард УНТЭ, СЭМҮТ, ХСҮТ эмнэлгүүд лабораторийн шинжилгээний хүлээгдэлгүй ажилласан байна. Хүлээгдэл үүссэн УХТЭ болон УГТЭ-ээр нийт 1366 үйлчлүүлэгчээр лабораторийн шинжилгээ өгсөн бөгөөд 1180 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн бол 186 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн байна. Энэ нь өмнөх 2 дугаар сарын хүлээгдлээс 80 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. УХТЭ болон УГТЭ-ийн хувьд сүүлийн хоёр сар тогтмол хүлээгдэлтэй байгаа лабораторийн шинжилгээгээр биохимийн шинжилгээ байна. УХТЭ-ийн биохимийн шинжилгээний хүлээгдэл өмнөх сарынхаас 50, УГТЭ-ийн биохимийн шинжилгээний хүлээгдэл өмнөх сарынхаас 10 хүлээгдлээр тус тус нэмэгдсэн байгаагаас тус кабинет харьцангуй ачаалалтай ажиллаж байгаа нь харагдаж байна.

Дөрөв. Хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2020 оны 3 дугаар сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УНТЭ, УХТЭ, УГТЭ, СЭМҮТ, ХСҮТ-дэд бүртгэн мэдээлснийг нэгтгэн дүгнэв.

Хэвтэн эмчлүүлэх тасгийн хүлээгдлийг ЭМБ-аар:

УХТЭ-т хэвтэн эмчлүүлэх мэс заслын тасагт нийт 10 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хэвтэн эмчлүүлэх тасгийн хүлээгдлээс 116 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр буурсан байна. Үүнд: Мэс заслын тасагт 7-14 хоногийн хүлээгдэлтэй 5 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 5 үйлчлүүлэгч тус тус бүртгэгдсэн байна.

УГТЭ-ийн хэвтэн эмчлүүлэх 7 тасгийн нийт 151 хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 15 хүлээгдлээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнд:

Бөөр судлалын тасаг 1-3 хоногийн хүлээгдэлтэй 7, зүрх судасны тасагт 1-3 хоногийн хүлээгдэлтэй 2, 3-6 хоногийн хүлээгдэлтэй 3, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 3 үйлчлүүлэгч, уушгины тасагт 3-6 хоногийн хүлээгдэлтэй 7 үйлчлүүлэгч, мэс заслын тасагт 1-3 хоногийн хүлээгдэлтэй 5, 3-6 хоногийн хүлээгдэлтэй 5, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 4 үйлчлүүлэгч, мэдрэлийн мэс заслын тасагт 1-3 хоногийн хүлээгдэлтэй 16, 3-6 хоногийн хүлээгдэлтэй 10, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 12, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 3 үйлчлүүлэгч, чих хамар хоолойн тасагт 1-3 хоногийн хүлээгдэлтэй 15, 3-6 хоногийн хүлээгдэлтэй 12, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 20, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 18 үйлчлүүлэгч, зүрх судасны мэс заслын тасагт 1-3 хоногийн хүлээгдэлтэй 4, 3-6 хоногийн хүлээгдэлтэй 5 үйлчлүүлэгч тус тус бүртгэгдсэн байна.


СЭМҮТ-ийн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт нийт 92 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд: 1-3 хоногийн хүлээгдэлтэй 9, 3-6 хоногийн хүлээгдэлтэй 5, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 38, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 40 үйлчлүүлэгч байна.

ХСҮТ-д нийт 281 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр ор хүлээж байна. Үүнд: 1-3 хоногийн хүлээгдэлтэй 48, 3-6 хоногийн хүлээгдэлтэй 70, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 80, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 70, нэг сараас дээш хоногийн хүлээгдэлтэй 10 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

УХТЭ, УГТЭ, СЭМҮТ, ХСҮТ-үүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн 2020 оны 3 дугаар сарын хүлээгдлийг тасгаар харьцуулсан нь:

№	ҮЗЛЭГИЙН КАБИНЕТЫН НЭР	УХТЭ	УГТЭ	СЭМҮТ	ХСҮТ	НИЙТ
1	Бөөр судлалын тасаг	7	5	-	-	12
2	Зүрх судасны тасаг	8	5	-	-	13
3	Уушгины тасаг	-	5	-	-	5
4	Мэс заслын тасаг	38	5	-	-	43
5	Мэдрэлийн тасаг	-	1	-	-	1
6	Чих хамар хоолой тасаг	-	35	-	-	35
7	Мэдрэлийн мэс засал	-	85	-	-	85
8	Стресээс шалтгаалсан сэтгэцийн эмгэг судлалын тасаг	-	-	92	-	92
9	ЕМЗ-ийн тасаг	-	-	-	11	11
10	ЭЦНБ-ийн тасаг	-	-	-	42	42
11	Туяа эмчилгээний тасаг	-	-	-	22	22
12	Өдрийн туяа эмчилгээний тасаг	-	-	-	15	15
13	Химиин эмчилгээний тасаг	-	-	-	65	65
14	Өдрийн химиин эмчилгээний тасаг	-	-	-	43	43
15	Хөнгөвчлөх эмчилгээний тасаг	-	-	-	31	31
16	Ангиографийн тасаг	-	-	-	52	52
Нийт хүлээгдэл		46	136	92	281	555

УХТЭ, УГТЭ, СЭМҮТ, ХСҮТ-үүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн 2020 оны 3 дугаар сарын хүлээгдлийг хоногоор харьцуулсан нь:



Дүгнэлт: УНТЭ, хэвтүүлэн эмчлэх тасгууд хүлээгдэлгүй ажилласан байна. УХТЭ, УГТЭ, СЭМҮТ, ХСҮТ-ийн хэвтүүлэн эмчлэх тасгуудад 3-6 хоногийн хүлээгдэлтэй 117 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 162 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 139 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хоногийн хүлээгдэлтэй 10 үйлчлүүлэгч нийт 428 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээсэн байна.

Тав. НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

НЭМГ-ын харьяа 6 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд:

1. Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төвийн мэдрэлийн тасагт 7, дотрын тасагт 22, ахмадын эмнэлэгт 79 орны хүлээгдэл;
2. Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төвийн дотрын тасагт 16 орны хүлээгдэл;
3. Налайх дүүргийн эрүүл мэндийн төвийн мэдрэлийн тасагт 8, дотрын тасагт 30 орны хүлээгдэл;
4. Багануур дүүргийн эрүүл мэндийн төвийн мэдрэлийн тасагт 13 орны хүлээгдэл;
5. Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвийн мэдрэлийн тасагт 11, дотрын тасагт 14, ахмадын эмнэлэгт 31 орны хүлээгдэл;
6. Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн дотрын тасагт 25 орны хүлээгдэл тус тус бүртгэгдсэн байна


НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлийг хоногоор харьцуулбал:

№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	СХД ЭМТ	ХУД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ
			3 сар					
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтөний тоо	7	0	8	13	11	

		1-3 хоног			2		8	
		3-6 хоног	7		4	6	3	
		7-14хоног			2	4		
		15-30 хоног				3		
		1 сараас дээш						
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтөний тоо	22	16	30	0	14	25
		1-3 хоног		6	13		8	12
		3-6 хоног	22	10	11		6	13
		7-14хоног			3			
		15-30 хоног			3			
		1 сараас дээш						
4	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтөний тоо	79	0	0	0	31	0
		1-3 хоног	9				4	
		3-6 хоног	22				5	
		7-14хоног	48				22	
		15-30 хоног						
				1 сараас дээш				

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 3-р сард 21010 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх сарын дуудлагаас 6312 дуудлагаар буурсан байна. Нийт дуудлагын 46.5%-ийг 0-20 минутад, 32.9%-ийг 21-40 минутад, 13.4%-ийг 41-60 минутад, 7.2%-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2019 оны 10 дугаар сараас 2020 оны 3 дугаар сар хүртэлх сүүлийн 6 сард ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА